

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ДАГУУ ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ**

2023.06.15

Сүмбэр

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Оноо
<b>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр</b>					
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнөөс өөрийн байгууллагад хамааралтай заалтуудыг хяналтад авч, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, тайлагнах	2, 4 дүгээр улиралд	Хөтөлбөрийн тоо  Хэрэгжилтийн хувь	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 зорилтын 9 арга хэмжээний биелэлт /75%/, Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8 зорилтын 58 арга хэмжээний биелэлт /81/, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 зорилтын 74 арга хэмжээ /81,6%/, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний 6 зорилтын 77 ажил арга хэмжээний биелэлт /81.9/-ийн өөрийн байгууллагад хамааралтай заалтуудыг хяналтад авч, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.	80
2	Бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай” А/147 дугаар захирамжид заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг бодитой үнэлэх, 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тайлагнах	Тухай бүр	Журмын хэрэгжилт	Байгууллагаас хэрэгжүүлж биелэлт үр дүнг тайлагнах 11 төрлийн бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай” А/147 дугаар захирамжид заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлэн хугацаанд нь хүргүүлсэн.	100
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төвлөхдөө шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, хүрэх түвшингийн үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар илэрхийлж хэмжигдэхүйцээр төлөвлөх	Тухай бүр	Журмын хэрэгжилт	Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон, ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, хүрэх түвшингийн үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар илэрхийлж хэмжигдэхүйцээр төлөвлөсөн ба албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхөд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100

4	Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлж байхад анхаарах	Тухай бүр	Хугацаандаа хүргэгдсэн хувь	Байгууллагаас хэрэгжүүлж биелэлт үр дүнг тайлагнах 11 төрлийн бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн.	90
<b>Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ</b>					
<b>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх</b>					
5	Сумын стратеги төлөвлөгөөг 4 жилээр төлөвлөн, баталж хэрэгжилтийг ханган ажиллах.	1-р улиралд	Батлуулсан эсэх	Сүмбэр сумын стратеги төлөвлөгөөг батлуулахаар төсөл хэлбэрээр бэлтгэсэн байна.	30
6	Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр өгөөжийг дээшлүүлэх	Жилдээ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 9 хөрөнгө оруулалт, их засвар, бараа тоног төхөөрөмж худалдан авах цахим тендер шалгаруулалтыг төлөвлөсөн. Тус төлөвлөлтийн хүрээнд хөрөнгө оруулалтын 5 ажлыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 81,1 хувьтай байна.	81.1
7	Төрийн үйлчилгээг цахимжуулах, хөдөөгийн багийг интернэт сүлжээнд холбох, иргэдэд төрийн үйлчилгээний e-mongolia системийг сурталчилж, иргэдэд үйлчлэх төвийг өргөтгөн, операторын системийн үйл ажиллагааг бүрэн хангаж ажиллах. Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг дээшлүүлж, тоон гарын үсгийг нэмэгдүүлэх, төрийн цахим шууданг нэвтрүүлэн ашиглах. Тусгай зөвшөөрөл, өргөдөл, гомдол болон бусад шаардлагатай төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэх. Сумын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэхэд анхаарах	2-3-р улиралд	Интернет сүлжээнд холбох багийн тоо Зохион байгуулсан арга хэмжээний тоо Албан хэрэг хөтлөлтийн цахимжуулалтын хувь e-mongolia системд орсон үйлчилгээний тоо олгосон лавлагааны төрөл лавлагааны тоо цахимаар хүлээж авсан өргөдлийн тоо Шийдвэрлэлтийн хувь Цахим хуудасны баяжилтын хувь, хандал таар	Сүмбэр сумын 6-р багийн нутаг дэвсгэр Малх толгойд үүрэн телефоны дахин дамжуулах станц байрлуулах ажлыг Unitel ХХК хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 30 км радиустайгаар барих бөгөөд 6-р багийн 243 өрх сүлжээнд бүрэн холбогдсон байна. Хөдөөгийн малчдад багийн өдөрлөг, уулзалтаар e-mongolia системийг ашиглаж хэрхэн лавлагаа мэдээлэл авах талаар нийт 150 малчинд арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн E-mongolia системийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд 210 иргэнд гарын авлага материал тарааж 51 иргэний гар утсанд апп татан өгч арга зүйгээр хангаж ажилласан. E-монголиа системийн брендбүүкээр ХУРДАН буланг шинээр байгууллагын 1 давхарт үүсгэж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Эхний 6 сарын байдлаар 11 төрлийн 234 лавлагаа олгосон байна. Архив албан хэрэг хөтлөлтийн ERP программ дээр 220 ирсэн, 105 явсан албан бичгийг тухай бүрд нь бүртгэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын цахим шуудан болох email-ийг ашиглан мэдээлэл солилцон мэдээллийн сан үүсгэн лавлагаа, мэдээ тайланг	90

				<p>хүлээн авах, яаралтай албан тоотыг хүргүүлэх, хүлээж авах зэрэг ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар нийт 334 албан бичиг ирж, 297 албан бичгийг холбогдох газруудад хос бичгээр явуулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт заавар журмын дагуу бүртгэлжүүлсэн. Байгууллагын архивын өрөөг засаж тохижуулах ажил хийгдэж байна.</p> <p>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia-д тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бүрдүүлэх шинэчилсэн мэдээллийг оруулан цахимаар 5 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн. Энэ оны эхний 5 сарын байдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт-69 өргөдөл, гомдол санал хүсэлт ирсэн. Нийт 69 өргөдлийн 10 өргөдөл шийдвэрлэх шатанд хуулийн хугацаанд, 59 өргөдлийг бүрэн шийдвэрлэж 85%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Байгууллагын сайт болон фэйсбүүк хуудсаар сум, багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын ажлын талаарх мэдээллийг цаг бүр, тухай бүрт нь мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэн ажиллаж байгаа ба мөн сар бүрийн хийсэн ажлын тайланг видео хэлбэрээр түгээж байна. Сүмбэрийн мэдээ фэйсбүүк хуудсанд Нийт 622 мэдээлэл /өөрсдийн бэлтгэсэн 287, бусад байгууллагын 335 мэдээлэл/ байршуулж давхардсан тоогоор 10800 хүний хандалт авсан байна.</p>	
8	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх	Улирал бүр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан албан хаагчдын хувь Албан хаагчдын цаг ашиглалтын хувь	Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай сумын Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаанд үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Байгууллагын албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөлөгөөг батлуулан,	100

				<p>төлөвлөгөөний дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, ажилтан, албан хаагчдын хоорондын харилцаа хандлагыг сайжруулах, цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр “Хариуцлагатай албан хаагч-Бидний үнэт зүйл” сарын аяныг 2023 оны 03 сарын 01-ны өдрөөс 03 сарын 31-ны өдрийн хугацаанд зохион байгуулан ажилласан. Ажлын цаг ашиглалтыг сайжруулах үүднээс төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ээр цаг бүртгэлийг хийж цаг ашиглалт 90 хувь байна.</p>	
9	<p>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог нөхөж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах</p>	Жилдээ	<p>Зохион байгуулсанн арга хэмжээний тоо</p> <p>Хамрагдсан албан хаагчдын хамрагдалтын хувь</p>	<p>Байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалтад 1 албан хаагч, анхан шатны сургалтад 1 албан хаагч, АЗ сургалтад нийт 4 албан хаагч хамрагдаж тэнцсэн. Байгууллагын нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж 8 албан сертификат авсан. Сумын Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны 6 албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж 3 сул орон тоо нөхөгдсөн. Төрийн захиргааны албан хаагчдыг орон нутагт ажилласны нэмэгдэл 100%, үйлчилгээний албан хаагчдын цалин 26 хувиар нэмэгдсэнийг цалин сандаа багтаан олгон ажиллаж байна.</p>	90

10	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, иргэд, олон нийтийн оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар мод, бут тарьж ургуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.</p>	Жилдээ	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо Тарьсан модны тоо Ургалтын хувь</p>	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын тариалалтаар төрийн 31 байгууллагын 650 албан хаагч мод үржүүлгийн газрын хуваарьт талбайд аймгийн хилийн зурвас хэлбэрээр 2600 хайлаас модыг зурваслан тарьлаа. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ойн зурваст төрийн болон орон нутгийн өмчийн 24 байгууллага 863 мод нөхөн тарьж, усалгаа, арчилгааг хариуцан ажиллаж байна. Төвийн 3 багийн 569 өрх 4 нэр төрлийн 1940 ширхэг модыг хашаандаа тарьж арчилж байгаа ба 19 иргэн нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэн, засмал зам дагуу 5 нэр төрлийн 568 ширхэг модыг тарьж, арчилгаа хамгаалалтыг хийн ажиллаж байна. Төвийн 3 багт үйл ажиллагаа явуулдаг томоохон 24 байгууллагаас 6 байгууллага өөрийн эзэмшлийн талбайд 2400 модыг тарьж, усалгаа, арчилгааг хариуцан хийж, өөрийн эзэмшил газарт мод тарих боломжгүй үйлдвэрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 3 компани нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэнд 6 нэр төрлийн 600 мод, бутыг тарьсан. Нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэнгийн 1600 модны усалгаа, арчилгаа, хамгаалалтыг 6 сарын хугацаатай хариуцуулахаар 1 ААН-тэй гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 онд ШШГ-425-р анги 35,000 модны суулгацыг бэлтгэн борлуулсан. 2022 онд тарьсан модны ургалтын хувь 87,9 хувь байна.</p>	100
11	<p>Сумын хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, төвлөрсөн хогийн цэгийг сайжруулах, олон нийтийн оролцоог хангаж, хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах арга хэмжээний менежментийг сайжруулах замаар хог хаягдлыг бууруулах.</p>	Жилдээ	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо Байгуулсан цэгийн тоо Гүйцэтгэлийн хувь</p>	<p>Сумын хэмжээнд барилгын туурь, хур хог хаягдал бүхий 268.6 га талбай байдгаас нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд, ААНБ-ыг татан оролцуулан 18 газрын 20 га талбайг цэвэрлэх ажлыг 8-р сард зохион байгуулахаар төвлөлөн 19,0 сая төгрөгийг төсөвлөн батлуулаад байна. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, аймгийн Мал эмнэлгийн газар, малчидтай хамтран 4, 5, 6-р багийн нутаг дэвсгэрт төвлөрсөн 300 орчим бод,</p>	100

				650 орчим бог нийт 210 тонн малын сэг зэм хог хаягдлыг цэвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж төвлөрсөн хогийн цэгт булж устгал хийгээд байна. Мөн Хоггүй Сүмбэр пэйж хуудсыг ажиллуулан төрийн болон орон нутгийн өмчийн 32 байгууллагууд 14 хоног тутамд нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээг зохион байгуулж, хийсэн ажлаа тайлагнаж ажиллаж байна. □□□□"Хүн бүр байгаль хамгаалагч" аянд нэгдэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 28 байгууллага, 150 гаруй иргэдийг хамруулан 2 цэцэрлэгт хүрээлэнг цэвэрлэж 36 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.	
12	Ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийг ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, Сум хөгжүүлэх сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үр нөлөөг дээшлүүлэх.	Жилдээ	Ажилгүй иргэдийн тоо Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Сумын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэггүй 640 иргэний судлагааг гарган хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт 2023.03.17-ны 01/149 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд байнгын ажлын байранд 20, түр ажлын байранд 160 иргэнийг хамруулсан. Сумын хэмээнд "Нэг өрх, нэг ажлын байр" хөтөлбөрийн хүрээнд 60 айл өрхийг сонгон аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газартай хамтран ажлын байраар хангах ажлын хүрээнд албан байгууллага бүрт хуваарилан өгсөн.	80
13	Аймаг, сумын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулж, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх	Жилдээ	Хэрэгжилтийн хувь	Аймаг, сумын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ /85.9%/, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг эхний хагас жилээр 80,2 хувьтай үнэлүүлсэн.	83
<b>Байгууллагын нээлттэй байдлыг сайжруулах чиглэлээр</b>					
<b>Байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр</b>					
14	Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хууль болон Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" тогтоолын дагуу мэдээлж, тогтмол шинэчилж байх	Жилдээ	Тогтоолын хэрэгжилт  Цахим хуудасны баяжилтын хувь  Хандалт	Байгууллагын <a href="http://sumber.gs.gov.mn">sumber.gs.gov.mn</a> хаягын вэйб хуудсанд 9 цэсэнд 106 мэдээлэл байршуулсан. Үүнд: мэдээллийн ил тод байдал 73, виео мэдээ 13, цаг үеийн мэдээ 20 байна Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын тендерийн урилга, үр дүн болон хийгдсэн ажлуудын хэрэгжилтийг тогтмол байгууллагын цахим хуудас, олон нийтийн	90

				сүлжээгээр дамжуулан 23 мэдээлэл байршуулан иргэдэд хүргэсэн.	
15	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулах, тогтмол шинэчлэх	Сар бүр	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбарт сар бүр 5 удаа, шилэн дансанд тухай бүр нийт 138 мэдээлэл, худалдан авах ажиллагаатай холбоотой 23 мэдээлэл байршуулсан.	85
<b>Шилэн дансны мэдээлэл</b>					
16	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь оруулж байх	Сар бүр	Мэдээлэл оруулсан байдал	Шилэн дансны цахим системд ОНХС-д 72 мэдээлэл оруулж 5 мэдээлэл хугацаа хоцроосон, Засаг даргын тамгын газар 66 мэдээлэл оруулж, 7 мэдээлэл хоцроож оруулсан байна. Санхүүгийн хяналт аудитын албанаас эхнй 3 сарын байдлаар шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалт хийж, ирэлсэн зөрчлийн дагуу 3 мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгасан.	85
17	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах	Жилдээ	Хуулийн хэрэгжилт	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн төсвийн төлөвлөгөө 1966677,1 мян төгрөг, үүнээс гүйцэтгэл 1955377,1 мянган төгрөг зарцуулж хэмнэлт 11300,0 төгрөг байна.	100
<b>Шударга байдлын түвшний үнэлгээ</b>					
18	Захирамж, тушаалд тогтоол, журам үндэслэж байгаа тохиолдолд баталсан субъект, он, дугаар, нэрийг тодорхой бичих. Өөрт хамаарахгүй зүйл заалтыг үндэслэхгүй байх. Хүчингүй болсон хууль, тогтоол, дүрэм журам үндэслэхгүй байх	Тухай бүр	Хэрэгжилтийн хувь	Захирамж, тушаалд тогтоол, журам боловсруулахдаа албан тушаалтнуудаар хянуулах зөвшөөрлын хуудсаар хянуулж гаргуулан ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллаж байна.	100
19	Байгууллагынхаа авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна. Төлөвлөгөөг илүү тодорхой, цаг хугацаатай хүрэх үр дүнтэй төлөвлөх шаардлагатай. Хэрэгжилтийг тоо баримттай, тодорхой үр дүнд хүргэж тайлагнах.	Жилдээ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний хүрээнд АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэрэг 6 төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /файсбүүк/-д байршуулан иргэдэд хүргэсэн. Монгол Улсын Засгийн газраас "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "ШҮГЭЛ АЖИЛЛАГАА"-г зарласантай холбогдуулан	80

				авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан “НЭГДЬЕ”, “ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД ӨӨРЧИЛЬЕ” аяныг иргэдэд байгууллагад вэб сайт, фэйсбүүк хаягаар сурталчилсан. Дээрх аянд байгууллагын 28 албан хаагч нэгдсэн. Төрийн захиргааны ажилтнуудын ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулан хугацаанд нь тайлагнасан.	
<b>Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр</b>					
20	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	2,3-р улиралд	Чанарын менежментийн тогтолцоо" ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлж баталгаажсан байна.	“Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай сумын Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаанд үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх байгууллагын чанарын багийн 2 албан хаагч 2 хоногийн сургалтад хамруулж стандартыг баримт бичгийг боловсруулаад байна. Мөн Е-монголиа системийн брендбүүкээр ХУРДАН буланг шинээр байгууллагын 1 давхарт үүсгэж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.	80
21	Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх. Ёс зүйн зөвлөлийг журмын дагуу ажиллуулж, үйл ажиллагаа, үр дүнг цахим хуудсанд мэдээлэх.	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан албан хаагчдын хувь Цахимд байршуулсан мэдээллийн тоо	Байгууллагын албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, ажилтан, албан хаагчдын хоорондын харилцаа хандлагыг сайжруулах, цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр “Хариуцлагатай албан хаагч-Бидний үнэт зүйл” сарын аяныг 2023 оны 03 сарын 01-ны өдрөөс 03 сарын 31-ны өдрийн хугацаанд зохион байгуулан ажилласан. Ажлын цаг ашиглалтыг сайжруулах үүднээс төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн	100



				систем /ERP/-ээр цаг бүртгэлийг хийж байна. Мөн ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө үйл ажиллагааг байгууллагын вейб хуудсанд байршуулсан.	
22	Хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог зарлан нөхөж, зөрчилтэй томилгоог арилгах, холбогдох мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Хуулийн хэрэгжилтийн хувь	Төрийн албаны сул орон тоог тухай бүр зарлан байгууллагын мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулан, Сумын Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны 6 албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж 3 сул орон тоо нөхөгдсөн. Зөрчилтэй томилогдсон албан хаагч байхгүй.	100
23	Төрийн албан хаагчдыг томилсон, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан тухай дүгнэлт болон төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргасан шийдвэрүүдийг цахим хуудсанд байршуулах.	Тухай бүр	Цахимд байршуулсан мэдээллийн тоо	Байгууллагын цахим хуудсанд төрийн албан хаагчдыг томилсон, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан тухай дүгнэлт болон төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргасан шийдвэрүүдийг байршуулах ажил 70 хувьтай хэрэгжиж байна.	70
24	Төрийн байгууллагын хүний нөөцийн нэгдсэн системийн үйл ажиллагааг хангаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэн, тухай бүр өөрчлөлт баяжилтыг хийх, байгууллагын албан хаагчдын танилцуулга мэдээллийг цахим хуудсанд байршуулах.	Жилдээ	Журмын хэрэгжилтын хувь	Хүний нөөцийн нэгдсэн систем шинэчлэгдсэнтэй холбоотой тухай бүр өөрчлөлтийг хийж, албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу шинээр бүрдүүлэн, тухай бүр өөрчлөлт баяжилтыг хийж, <a href="http://sumber.gs.gov.mn">sumber.gs.gov.mn</a> хаягын вэйб хуудсанд албан хаагчдын харилцах утасны дугаар, шуудангийн хаяг зэргийг байруулсан ба албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг байршуулж байна.	90
25	Байгууллагын бүтэц орон тоог хууль, тогтоомжийн хүрээнд тогтоож, бүтэц орон тооны дагуу албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох мэдээ мэдээллийг ил тод байршуулах.	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулах Байршуулсан мэдээлэл	Байгууллагын бүтэц орон тоог Тамгын даргын 2023.01.03-ны өдрийн А/01 тоот тушаалаар баталсан бөгөөд албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг 2022 оны 09 сард боловсруулан төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Одоогоор Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллаж байна.	100
26	Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд батлан мөрдүүлэх. Дотоод журмын хэрэгжилтийг ил тод мэдээлэх.	Жилдээ	Журмын хэрэгжилт	Байгууллагын дотоод журмын ЗДТГ-ын даргаар 2022 оны 04 сард шинэчлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд байгууллагын цахим хаягт ил тодоор мэдээлэн байршуулсан.	100
<b>Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээ</b>					

<b>Ногоон байгууламж</b>					
27	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг 2023 оны төсөвт төлөвлөгөөнд тусгаж ажиллах	1-р улиралд	Төсөв төлөвлөгөөнд тусгуулах	2023 оны төсөвт Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг 3 арга хэмжээ бүхий 42,0 сая төгрөг тусган батлуулсан.	100
28	Иргэн бүр, албан байгууллага бүрээр мод тариулах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг тооцох	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Тарьсан модны тоо  Ургалтын хувь	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн бүр, албан байгууллага бүрээр мод тариулах арга хэмжээг идэвхжүүлэх зорилгоор мод тарих өдрөөр сумын хэмжээнд хаврын мод тарилтын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан иргэдэд 2500 мод үнэгүй тараасан бөгөөд мөн 31 байгууллагын 650 албан хаагч мод үржүүлгийн газрын хуваарьт талбайд аймгийн хилийн зурвас хэлбэрээр 2600 хайлаас модыг зурваслан тарьсан. Ургалтын хувийг 9 сард тооцон гаргана.	100
<b>Хог хаягдал</b>					
29	Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө гарган, шаардлагатай төсөв санхүүжилтийг 2023 төсөвт тусгах	Жилдээ	Төсөв төлөвлөгөөнд тусгуулах	Сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлуулахаар ИТХ-аар өргөн барьж танилцуулсан. Уг төлөвлөгөөнд Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачлага гаргах, зохион байгуулах үүрэг бүхий “Чойр дахивар эрдэнэ” хоршоотой хамтран ажиллаж идэвхижүүлэх, аян зохион байгуулах чиглэлээр 6,0 сая төгрөг төсөвлөгдсөн.	70
30	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог цэвэрлэгээний ажлыг иргэн, аж ахуйн нэгж, төсвийн байгууллагын оролцоотой тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох	Жилдээ	Цэвэрлэгээний  Хамрагдсан ААНБ тоо	Сумын хэмжээнд “Хоггүй Сүмбэр” пэйж хуудсыг ажиллуулан төрийн болон орон нутгийн өмчийн 32 байгууллагууд 14 хоног тутамд нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээг зохион байгуулж, хийсэн ажлаа тайлагнаж ажиллаж байна. □□□□ Уг цэвэрлэгээний тайланг аймгийн удирдах аилтны шуурхай зөвлөгөөнд тогтмол танилцуулан үр дүнг тооцон ажиллаж байна. ”Хүн бүр байгаль хамгаалагч” аянд нэгдэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 28 байгууллага, 150 гаруй иргэдийг хамруулан 2 цэцэрлэгт хүрээлэнг цэвэрлэж 36 тн хог хаягдал, бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулан 34 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.	100
31	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үйл ажиллагааг	Жилдээ	Хяналт тавьж ажилласан байдал	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд	100

	сайжруулах, стандартад нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх			тогтмол хяналт тавьж, сар бүр хог хаягдлын тайланг авч, үр дүнг тооцон ажиллаж байна.	
<b>Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн зөвлөмж</b>					
32	Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг удирдах, төсвийн орлогыг нэмэгдүүлж, бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх	Жилдээ	Эдийн Засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хувиар	Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 2 үзүүлэлт 53 заалтаар эхний хагас жилийн байдлаар гаргаж 83,6 хувийн үзүүлэлттэй байна.	83,6
33	Багийн засаг дарга нарын үйл ажиллагааг сайжруулах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх	Жилдээ	Зохион байгуулсан сургалтын тоо	Багийн засаг дарга нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод сургалтад 6 удаа, Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулсан “Алсын хараа 20-50 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлууд” сэдэвт зөвлөлдөх уулзалтад хамруулсан бөгөөд багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг иргэдэд ойр хүртээмжтэй хүргэх үүднээс 7 хоног бүрийн 1 өдрийг гадуур ажлын өдөр болгон айл өрх, албан байгууллагуудаар биечлэн орж санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх талаар хуваарь гарган мөрдүүлэн, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Засаг дарга, Орлогч дарга, Тамгын даргын зүгээс тогтмол арга зүйгээр ханган ажиллаж байна	80
34	Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, ёс зүй хариуцлагыг дээшлүүлэх, иргэдэд хүрч ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан албан хаагчдын хувь Албан хаагчдын цаг ашиглалтын хувь	Эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй бөгөөд энэ чиглэлээр бусад байгууллагаас харилцаа хандлага, төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг 03 сарын 10-ны өдөр зохион байгуулж, уг арга хэмжээнд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Нийгмийг даатгалын хэлтэс оролцож иргэдэд ОНХС-аар 2022 онд хийгдсэн ажил, E-Mongolia гар утсан дээрээ хэрхэн ашиглах, өөрийн өмчлөлийн газраа хэрхэн шалгах талаар зааварчилгаа, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, аюул, осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийж гарын авлага тараан, 161 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн E-монголиа системийн брендбүүкээр ХУРДАН буланг шинээр	100

				байгууллагын 1 давхарт үүсгэж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.	
35	Сумын төвийн тохижилтыг сайжруулах, ногоон байгууламж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээ	Сүмбэр сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “3-р багийн нутаг дэвсгэр Баянбулагийн эгнээнд 100 ширхэг гэрэлтүүлгийг хийсэн бөгөөд энэ онд Гашуун, Баянбулагийн эгнээнд 100 гэрэлтүүлгийг нэмж суурилуулах ажлын техникийн тодорхойлолт боловсруулагдаж байна. Хаврын тариалалтаар 10,571 мод тарьж ногоон байгууламж 1,2 га талбайгаар нэмэгдсэн. Ургалт арчилгааг сайжруулах зорилгоор нийтийн эзэмшлийн 2 цэцэрлэгт хүрээлэнгийн 1600 модны усалгаа, арчилгаа, хамгаалалтыг 6 сарын хугацаатай хариуцуулахаар 1 ААН-тэй гэрээ байгуулан ажиллаж байна.	80
36	Сууц өмчлөгчдийн холбоог нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн орон сууц, эдэлбэр газрын ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах	Жилдээ	СӨХ байгуулсан байна.	Найрамдал хотхоны СӨХ-ны удирдах зөвлөлийг шинэчлэн баталж удирдах зөвлөлийн даргаар О.Одгэрэл, гишүүдээр 7 иргэн, хяналтын зөвлөлөөр 2 иргэн, гүйцэтгэх захирлаар Д.Доржпүрэвийг сонгосон.	50
37	Сумын төвийн камержуулалтыг сайжруулах, золбин муур нохой устгалын үйл ажиллагааг тогтмолжуулах, иргэдийн оролцоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Жилдээ	Нэмэгдсэн камерийн тоо Устгалын тоо Зохион байгуулсан арга хэмжээ	Ерөнхий боловсролын сургуулиудын камержуулалтын ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж хамгийн сайн үнэлэгдсэн “Сонголт нар” ХХК-тай 2023 оны 04 сарын 20-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ерөнхий боловсролын 1,2 сургуулиудын гадна дотор нийт 67 камерыг суурилуулснаар хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил болсон. Сумын Засаг даргын 03-р сарын 23-ны өдрийн А/67 дугаар захирамжийн дагуу “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГазар нь золбин нохой, муур устгалын ажлыг 1 удаа зохион байгуулж, 434 золбин нохой, 62 муурыг 9,920,000 төгрөгийг зарцуулан устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийн булж ажилласан.	100
38	Архидан согтуурахтай тэмцэх, архидалт үүсэх нөхцөлд дүн шинжилгээ хийж үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад анхаарах. Архи уусан хүмүүс олноор цугладаг агзарт анхаарал хандуулж, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран таслан зогсоох. Иргэд	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй гэр бүл хүчирхийлэлгүй ирээдүй” аяныг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулж байна. Тус аяны хүрээнд ахуйн хүрээнд архидан	30

	олон нийтрүү чиглэсэн нөлөөллийн ажлуудыг авч хэрэгжүүлэх.			согтуурдаг 40 айлд хяналт шалгалтыг удаа зохион байгуулан эрсдлийг бууруулан ажиллана.	
39	Хөдөөгийн багийн хөгжлийг хангах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр бүхий л талын дэмжлэгийг үзүүлэх.	Жилдээ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	Төрийн үйлчилгээг хөдөөгийн багийн иргэдэд хүрч үйлчлэх, хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа танилцуулах мэдээлэл хүргэх зорилгоор хөдөөгийн 3 багт 2023 оны 05 сарын 04-06-ны хооронд “Өдөрлөг” зохион байгуулсан бөгөөд уг өдөрлөгт төрийн болон хувийн хэвшлийн 18 байгууллага оролцож 288 малчид, иргэдэд мэдээлэл хүргэсэн. Өдөрлөг, уулзалтаар e-mongolia системийг ашиглаж хэрхэн лавлагаа мэдээлэл авах талаар нийт 150 малчинд арга зүйн зөвлөгөө өгч, Өрхийн эрүүл мэндийн төвөөс хөдөөгийн 4,5,6-р багт 3 удаагийн явуулын амбулаторын үйлчилгээ, томуугийн вакцин болон явуулын эхо, зүрхний бичлэг, эмийн сангийн үйлчилгээ, товлолын дархлаажуулалтад 209 өрхийн 731 иргэн, бага насны хүүхдийг хамруулсан. Эхний хагас жилийн байдлаар нийт өрхийн 38,3 хувийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулж өмнө оны мөн үеэс 7,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энхбилэг хувийн эмнэлгээс 5-р сард хөдөөгийн багуудын өдөрлөгт оролцож 275 иргэнд үнэ төлбөргүй үзлэг хийж, хеликобактерийн шинжилгээг төгрөгийн эмийн худалдаагаар үйлчилсэн байна. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн иргэний оролцоог дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийг түшиглэсэн халамжийн үйлчилгээ буюу 2,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх төсөлд сумын 6 иргэнийг хамруулсан.	90
40	Сумын харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлагаар хангаж үр дүнг тооцож ажиллах.	Жилдээ	Хяналт тавьж ажилласан байдал	Сумын хэмжээнд үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар 3 сургууль, 4 цэцэрлэгийн үйл ажиллагааны сургалтын чанар, үдийн хоолны чанарт нийт 2 удаагийн хяналт шалгалт хийж зөвлөн тусалж, арга зүйгээр хангаж ажилласан. Илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахаар сумын Засаг даргын албан бичгээр хугацаа зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилт 60 хувийн	80

				гүйцэтгэлтэй байна. Мөн “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, сар бүр хог хаягдлын тайланг авч, үр дүнг тооцон ажиллаж байна. Төрийн албаны цалингийн системд сумын харьяа байгууллага 3 сургууль, 4 цэцэрлэг, Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдын хурал, ӨЭМТөв, Тохижилт сүмбэр зэрэг аж ахуй нэгж байгууллагууд бүрэн хамрагдсан бөгөөд тогтмол хяналт тавин ажиллаж байна.	
41	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах. Зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах.	Жилдээ	Зээл олгосон үйлдвэрлэлийн тоо Хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийн хувь Нийт зээлийн эргэн төлөлтийн хувь	Аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгийн төсөл хүргүүлээд байна. 2023 онд хоршоо хөгжүүлэх сангаас 338 сая төгрөгийн зээлийг олгохоор сумын ИТХ-аар батлуулсан. Одоогоор жилийн эцсийн үлдэгдэл 123,1 сая төгрөг, эргэн төлөлтөөр 81,3 сая төгрөг, нийт 204,4 сая төгрөг төвлөрөөд байгаа бөгөөд сумын ИТХ-аар тэргүүлэх чиглэл батлуулж хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг олгохоор ажиллаж байна. Оны эхэнд нийт 43 зээлдэгчийн 908,6 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй үлдэгдэл байснаас 6 сарын 14-ны байдлаар 6 зээлдэгч 45,9 сая төгрөгийн зээлээ бүрэн төлж барагдуулан 19 зээлдэгч 28,7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлж нийт 74,6 сая төгрөг төвлөрүүлээд байна. 2023 оны 6 сарын 14-ны байдлаар төлөвлөгөөний дагуу 146,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 81.3 сая төгрөг төвлөрүүлж 55,6 хувийн эргэн төлөлттэй байна.	55,6
<b>Нийт үнэлгээ</b>					<b>85.9</b>

Тайлбар: Цахим шилжилтийн чиглэлээр өгсөн зөвлөмж нь 7 дахь заалттай давхцаж байгаа тул нэгтгэн тайлагнасан болно.